

ШАВАР ТООСГОН ДЭЭРХ БИЧЭЭСИЙН ТУХАЙ

Н.БАЯРХҮҮ

*ШУА-ийн Археологийн хүрээлэн,
e-mail:n_bayarkhuu04@yahoo.com*

Түлхүүр үгс: Архангай аймаг, Хөшөө Цайдам, Түрэгийн үе, руни бичиг

Өгүүллийн товч: *Хөшөө Цайдамд хаад, ихэст зориулсан тахилын цогцолбор байгууламжаас гадна мөн үед холбогдох тахилын онгон хэд хэд бий бөгөөд тэдгээр тахилын онгон, дурсгалын зарим нь Хөшөө Цайдамаас Өгий нуурын чиглэлд шинээр тавьж буй авто замын зурваст өртсөн тул ШУА-ийн Археологийн хүрээлэнгээс авран хамгаалах малтлага судалгааг 2007 оны 7-р сарын 15-наас 8-р сарын 01-ний хооронд хийж гүйцэтгэсэн байна. Авран хамгаалах малтлага судалгааны ажлын явцад хоёр мөр руни бичээс бүхий хэлтэрхий тоосго илрүүлсэн бөгөөд эл хоёр мөр бичээсийг шинжлэх ухааны эргэлтэд оруулах зорилгоор урьдчилсан байдлаар уншсанаа толилуулж байна.*

Орхон голын сав газар нь эртнээс нүүдэлчдийн төр улсаа байгуулан төвлөн сууж ирсэн өлгий нутаг билээ. Тиймээс ч чулуун зэвсгийн бууц суурин, дарханы газар, булш хиргисүүр, буган чулуу хийгээд хот балгадын туурь зэрэг түүхийн олон үеийг хамарсан дурсгал бий. XIX зууны сүүл үеэс буюу тодруулбал, 1889 онд Оросын Газар зүйн нийгэмлэгээс Н.М.Ядринцев, 1890 онд Фин-Угорын нийгэмлэгээс А. Хейкел, 1891 онд Оросын Шинжлэх ухааны академиас В.В.Радлов нарын удирдсан хээрийн шинжилгээний ангиуд ирж одоогийн Архангай аймгийн Хашаат сумын нутаг, Орхон голын баруун эрэг, Хөшөө Цайдам хэмээх газар буй Түрэгийн хаан Билгэ болон түүний дүү Көлтигин нарт зориулан үйлдсэн тахилын цогцолбор байгууламж хийгээд мөн аймгийн Хотонт сумын нутаг Орхон голын зүүн хөвөөнд орших Уйгурын улсын нийслэл Ханбалык буюу Орду балыкийн туурь болох Хар балгас хийгээд түүний гэрэлт хөшөөний бичээсийг судалж мэдээлснээр Орхоны хөндийн дурсгалууд дэлхийн олон эрдэмтэн судлаачдын анхаарлыг зүй ёсоор татах болжээ. Энэ үеийн судлаачид Билгэ хаан, Көлтигин нарт зориулан босгосон гэрэлт хөшөөний бичээсийг уншиж тайлах, орчуулан судлахад ихээхэн анхаарч ажилласан байдаг билээ.

Харин археологийн үүднээс малтан судлах ажил хожуу эхэлсэн бөгөөд анх Монгол-Чехсловакийн археологичид 1958-1959 онуудад, Көлтигинд зориулсан тахилын цогцолбор байгууламжийг, хожим Монгол-Туркийн археологичид 2000-2005 онд Билгэ хаанд зориулсан тахилын цогцолбор байгууламжийг тус тус малтан судалжээ.

Мөн Монгол-Зөвлөлтийн түүх соёлын хамтарсан хээрийн шинжилгээний анги, Монгол – Японы хамтарсан шинжилгээний анги, мөн түүнчлэн судлаач эрдэмтэд өөрсдийн зорилго, чиглэлийн дагуу судалгаа хийж олон арван бүтээл туурвисаар иржээ.

Хөшөө Цайдамд хаад ихэст зориулсан тахилын цогцолбор дурсгалаас гадна мөн үед холбогдох хэмжээгээр жижиг тахилын онгон хэд хэд бий. Тэдгээр тахилын онгоны зарим нь Хөшөө Цайдамаас Өгий нуурын чиглэлд шинээр тавьж буй авто замын зурваст өртсөн тул ШУА-ийн Археологийн хүрээлэнгээс авран хамгаалах малтлага судалгааг 2007 оны 7-р сарын 15-наас 8-р сарын 01-ний хооронд хийж гүйцэтгэсэн юм.

Тус өгүүлэлд дээрх авран хамгаарах малтлага судалгааны ажлын явцад олж илрүүлсэн нэгэн тоосгон дээрх руни бичээсийн талаарх судалгааг шинжлэх ухааны эргэлтэнд оруулах зорилгоор анх удаа урьдчилсан байдлаар уншиж мэдээлэхийг зорив.

Малтлагын өмнөх тахилын онгоны ерөнхий байдал

Уг онгоныг үйлдэхдээ саарал өнгийн том ширхэгтэй дөрвөн хавтгай боржин чулууг тэгшлэн засаж хайрцаглан газарт суулгасан байна. Тахилын онгоны нүүрэн талын болон хойд, урд талын хашлага чулууны дээд ирмэг газрын өнгөн хөрснөөс бага зэрэг цухуйж түүний дотор талд хонхорхой үүссэн байдалтай байв. Хойд урд хашлагын хоорондын зай 2.1 м байгаагаас харахад угтаа 2.1 х 2.1 м-ийн хэмжээтэй байсан бололтой. Тахилын онгоны нүүрэн талын хашлага чулууг гаргах, тахилын сүмийн барилгын шалыг тодруулах зорилгоор тахилын онгоны зүүн талын хэсэгт талбай үүсгэн доош малтахдаа малтлагын талбайг тахилын онгоны зүүн хашлагыг дайруулан уртрагийн дагуу 6 м урттай, хашлагаас зэл чулуу тийш өргөрөг дагуу 5 м өргөнтэй талбай үүсгэн малтлага судалгаа хийжээ. Малтлагын III үе буюу 25 см-ийн гүн хүртэл малтахад малын яс, хадгалалт муутай төмөр эдлэлийн үлдэгдлүүд бага хэмжээгээр илэрч байсан бөгөөд малтлагын гүн 45 см-г хүрэхэд тахилын хашлага чулууны дээд ирмэгийн хээтэй хугарсан хэсэг, ямар нэгэн зохион байгуулалтгүй барилгын материал болох шавар тоосгоны хагархайнууд болон руни бичээс бүхий шавар тоосгоны хагархай илэрчээ (Гүнчинсүрэн нар, 2007).

Бичээс бүхий шавар тоосгоны урт 20 см, өргөн 19 см, зузаан 4.5 см бөгөөд бичээсийг хурц үзүүртэй зүйлээр зурж бичжээ. Түрэг уйгурын үед тахилын онгоны чулуун хавтан болон ханын шаваас, тоосгон дээр руни бичээс бичиж үлдээх тохиолдол манай улсын хэмжээнд хэд хэд илэрч олоод байгаа билээ (Баттулга, 2005, 52-54). Тухайлбал, Архангай аймгийн Эрдэнэмандал сумын нутаг, Их Хануй нуурын бичээс, Булган аймгийн Могод сумын нутаг, Хөл Асгатын бичээс зэрэг нь тахилын хавтан чулуун дээр бичигдсэн байдаг. Монгол нутгаас шавар ваар дээр бичсэн дурсгал гурван олоод байгаа билээ. Үүнд Төв аймгийн Эрдэнэ сумын нутаг, Баянцогт хэмээх газарт орших Туньюкукт зориулан босгосон тахилын цогцолбор дурсгалын сүмийн ханын шаваас дээрх бичээс, мөн “Налайх”-ын хэмээн нэршсэн шавар хавтан дээрх бичээс, Завхан аймгийн Их уул сумын нутаг, Цэцүүхийн дурсгалаас илрүүлсэн дээврийн нөмрөг ваар дээрх бичээс эдгээр болно. Шавар ваар дээрх руни бичгийн дмөн руни бичээс бичсэн байдаг. Эдгээр бичээсүүд нь уг тахилын байгууламжийг үйлдэхдээ зориуд бичиж үлдээсэн бичээсүүд байдаг тул он цагийн хувьд эргэлзэх зүйлгүй нэг цаг үед холбогддог. Тиймээс шавар тоосгон дээр бичсэн энэ бичээс ч мөн адил тахилын онгонтой нэг цаг үед холбогдоно хэмээн үзэж байна.

Уг бичээс нь хоёр мөрөөс бүрдэх бөгөөд 1-р мөрийн урт 8.3 см, 4 (5?) үсэг тэмдэгттэй, харин 2-р мөрийн урт 17 см, 6 үсэг тэмдэгт болон тусгаарлах хос цэгээс тус тус бүрдэж байна. Үсгийн дундаж өндөр 3-4 см болно. 1-р мөрийн 3-р тэмдэгт нь чухам ямар үсэг болох нь тодорхойгүй, нэлээд эргэлзээтэй байгаа тул уншихад төвөгтэй юм. Харин 2-р мөрийн бичээс маш гаргацтай, тод байгаа билээ. Бичээсийг доорх мэт уншиж болохоор байна.

Бичээсийн эхийг сийрүүлбэл:

- ᠶ[ᠬ?]ᠶᠨ .1
ᠶ:ᠶᠬᠡᠶᠶᠨ.2

Үсгийн галиг:

1. QW(R?)W
2. QWmRW: k

Үгийн галиг:

1. qu(r?)ru
2. qumaru

Орчуулга:

1. Хуурай(?)
2. гэрээслэл (захиас үг)

Бичээсийн эхний мөрийн гуравдугаар үсэг нилээд эргэлзээтэй байгаа бөгөөд бид Ч (г) үсэг хэмээн үзлээ. Тоосго дээрх бичээсийн бусад үсэг тэмдэгт маш гаргацтай тод атал гуравдугаар үсгийг чухам юуны учир ийн тодорхой бус бичсэн нь ихээхэн анхаарал татаж байгаа бөгөөд бичиг судлаачид цаашид нарийвчлан судлах буй за.



Зураг. 1. Бичээс бүхий тоосго болон дардасын гэрэл зураг

НОМЗҮЙ

Баттулга Ц., 2005. Монголын руни бичгийн бага дурсгалууд, тэргүүн дэвтэр, - Corpus Insciporum, Tom.I, УБ, , х.52-54

Гүнчинсүрэн , Энхтөр А., Номгуунсүрэн Г., Алтанбагана А., 2007. Архангай аймгийн Хашаат сумын нутаг Хөшөө Цайдамаас Өгий нуур чиглэлд шинээр тавьж буй авто замын трасст өртсөн эртний дурсгалыг авран хамгаалах археологийн малтлага судалгааны ажлын эрдэм шинжилгээний тайлан, УБ. Археологийн хүрээлэнгийн гар бичмэлийн сан хөмрөг.

Древнетюркский словарь, 1969. Л., стр. 465

Sir Gerard Clauson, 1972. An Etymological Dictionary of Pre-Thirteenth Century Turkish, Oxford, p. 628

РЕЗЮМЕ

Н.Баярхуу

РУНИЧЕСКАЯ НАДПИСЬ НА ГЛИНЯННОМ КИРПИЧЕ

В знаменитом Кушо-цайдаме, кроме каганских поминальных сооружений также были обнаружены малые поминальные комплексы, которые подверглись разрушению вследствие проведения автотрассы между Кушо-цайдамом и Угий-нуром, из-за чего исследовательская группа от Института Истории АН Монголии провела спасательные работы, в ходе чего был обнаружен фрагмент кирпича из необожженной глины на которой были прочерчена руническая надпись из двух строк.

На первой строке были прочерчены 4 рунические буквы, которые по предварительному чтению являются, возможно древнетюркским словом “>[И?]>Н quru”, имеющее значение “сухой”, “высушенный”, а вторая строка из 6 букв и словоразделительного знака читается как слово “>:Ч»>Н qutaqu : k...”, имеющее общее значение “завещание”, “назидание” и т.п.